



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/149

Ховд

Чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын “а” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч Б.Батцэцэг нь ажлын зайлшгүй шаардлагаар чөлөө хүссэн тул 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дотоод журамд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Б.Батцэцэгийн чөлөөтэй хугацааны цалинг бодож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн Ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД